



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/71

Хөхбүрд

Хязгаарлалтын дэглэмийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагчийн 2025 оны 09 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Мэргэн 4 дүгээр багийн нутаг Ар гуугын худаг нэртэй газар үхэрт халдварт “Боом” өвчний халдварыг таслан зогсоох голомтыг устгах халдвар дамжих, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдрөөс 06 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл 7 хоногийн хугацаатай тогтоосон хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2.Малын халдварт боом өвчинтэй тэмцэх хариу арга хэмжээний дүгнэлтийг гаргаж голомтын болон сэжигтэй бүсийн мал, амьтны хашаа хороог халдваргүйжүүлэх, тандалтын судалгаа үзлэг, шинжилгээг давтан хийж, дээрх газарт мал, мах худалдах, малын отор нүүдэл, тээвэрлэлтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг, багийн Засаг дарга нарт, Хязгаарлалтын дэглэм шилжих үед хэрэгжүүлсэн ажлын тайланг аймгийн Мал эмнэлгийн газар болон холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Ж.Ёндонпил)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Гансүх)-д даалгасугай.

ДАРГА  Т.БЯМБАДОРЖ



642501083

